



БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2019/9
www.bulgan.nso.mn



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

www.1212.mn

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН

www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэлд
бүртгүүлснээр цахим
хаягаар тогтмол
авч болно.

Monstat ezStat
аппликейшн

Google play
App Store

1900-1212
Лавлах утас

@statistic_mn

Статистик
мэдээлэл

Үндэсний Статистикийн
Хорооны
НОМЫН САН

Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ
ХҮРГЭНЭ

ГАРЧИГ

Аргачлал тайлбар	4
Товч танилцуулга	8
I.1 Хүн ам	17
I.2 Хөдөлмөр	18
I.3 Нийгмийн халамж	19
I.3 Нийгмийн даатгал	20
I.4 Эрүүл мэнд	20
I.5 Гэмт хэрэг	21
II.2 Худалдан авах ажиллагаа	23
II.3 Үнэ	28
II.4 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	30
II.5 Малын үнэ	32
II.6 Аж үйлдвэр	33
II.7 Мал аж ахуй	34
II.8 Мал эмнэлгийн үйлчилгээ	38
II.10 Газар тариалан	39

Аргачлалын тайлбар

Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ. Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно. Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор

нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана. Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна. Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна. Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн

тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ. Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого,

түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна. Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна. ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана. Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг. Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм. ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлан үе

o - суурь үе

p_{it} - 'i' барааны тайлант үеийн үнэ,

p_{io} - 'i' барааны суурь үеийн үнэ,

q_{io} - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum - нийлбэрийн тэмдэг

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБаас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Хүн ам

Иргэний бүртгэлд шинээр төрсөн 678 хүүхэд, нас барсан 357 хүний бүртгэлийг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс шинэ төрсөн хүүхэд 122 буюу 17.9 хувиар буурсан бол нас баралт 120 буюу 33.6 хувиар өсжээ.

Зураг I.1.1

Бүртгэгдсэн төрөлт, нас баралт



611 хүн шилжин ирж, 659 хүн шилжин явсан нь өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн хүн 71 буюу 10.4 хувиар, шилжин явсан хүн 165 буюу 20.0 хувиар тус тус буурсан байна.

Зураг I.1.2

Бүртгэгдсэн шилжих хөдөлгөөн




I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэн 366 болсны 212 нь эмэгтэй байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.2 хувийг магистр болон докторын боловсролтой, 20.5 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 2.5 хувийг тусгай мэргэжлийн дунд, 4.9 хувийг техникийн болон мэргэжлийн, 59.3 хувийг бүрэн дунд боловсролтой, 9.3 хувийг суурь боловсролтой, 2.5 хувийг бага боловсролтой, 1.1 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.2.1


Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд



Аймгийн хэмжээнд ажил хайгч иргэдийн 19.4 хувийг 15-24 насны, 38.3 хувийг 25-34 насны, 24.6 хувийг 35-44 насны, 14.2 хувийг 45-54 насны, 2.7 хувийг 55-59 насны, 0.8 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.

Зураг I.2.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд боловсролын түвшингээр



I.3. Нийгмийн даатгал, халамж
Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 9177.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1975.4 сая төгрөг буюу 27.4 хувиар өсч, зарлага 30371.7 сая төг болж өмнөх оны мөн үеэс 3525.7 сая төг буюу 13.1 хувиар өссөн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 1483.5(24.7%) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 166(24.7%) сая төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 281.3(70.6%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 30371.7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн зарлага 3359.6(13.3%) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 92.4(9.8%) сая төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 132.2(34.1%) сая төгрөгөөр өсч, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 58.5(23.4%) сая төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн халамж

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 9656 хүн 3307.5 сая төгрөгийн тэтгвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 149.9 сая.төг буюу 4.7 хувиар өсч, нийгмийн халамжийн тэтгэвэрт 1047 хүн хамрагдаж 1482.5 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 139.5 сая.төг буюу 10.4 хувиар өссөн байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 786.6 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 49.2 сая.төг буюу 5.9 хувиар буурсан байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 6103 хүн хамрагдсаны 16.1 хувь ахмад настан, 3.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 80.9 хувь хүнс тэжээл хөтөлбөр хамрагдсан байна.




I.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 570 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 581 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 46 буюу 7.4 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 42 буюу 6.7 хувиар тус тус буурсан байна.

Зураг I.4.1


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



Нялхасын эндэгдэл 2019 оны 9 сарын байдлаар 10 гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулвал 2 буюу 16.7 хувиар буурсан байна.

Зураг I.4.2

Эндсэн хүүхэд, оноор



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 314 болж, өмнөх оны мөн үеийнхээс 19 тохиолдол буюу 6.1 хувиар өссөн байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 112 буюу 35.7 хувь нь амьсгалын замын халдварт өвчин, 139 буюу 44.3 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг I.4.3


Халдварт өвчнөөр өвчлөгсөд



Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг 349 бүртгэгдсэн 172 хэргийг илрүүлж өнгөрсөн оны мөн үеэс 80 хэргээр буюу 86.9 хувиар өссөн байна. Илрүүлэлтийн хувь 49.3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5.1 хувиар өссөн байна.

Зураг I.5.1

Бүртгэгдсэн гэмт хэрэг



Хэргийн өнгөөр нь авч үзвэл:

- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 82 бүртгэгдэж 3 хэргээр буюу 3.7 хувиар
- Хулгайлах гэмт хэрэг 77 бүртгэгдэж 21 хэргээр буюу 37.5 хувиар
- Мал хулгайлах гэмт хэрэг 89 бүртгэгдэж 74 хэргээр буюу 4.3 дахин
- Залилах гэмт хэрэг 19 бүртгэгдэж 11 хэргээр буюу 3.6 дахин
- Хүнийг алах гэмт хэрэг 4 бүртгэгдэж 4 хэргээр буюу 100 хувиар
- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 22 бүртгэгдэн 1 хэргээр буюу 4.7 хувиар тус тус өсч
- Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 21 бүртгэгдэж 3 хэргээр буюу 12.5 хувиар буурсан байна.



I.5 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 367 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 146 хэргээр буюу 62.6 хувиар өссөн байна.



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас нийт иргэд, аж ахуй нэгж байгууллагад 1217.4 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 1075.6 сая төгрөгний хохирол учирсан

байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 453.3 сая төгрөг буюу 37.2 хувийн хохирлыг нөхөн төлүүлж ажилласан байна.

Зураг I.5.3

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан иргэн



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол /сая.төг/

Хэргийн өнгөөр нь авч үзвэл: Гэмт хэргийн улмаас 97 хүн гэмтсэн нь ХЭМХБЭГХ-ийн улмаас 83 хүн, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 10 хүн, бусад хэргийн улмаас 4 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны мөн үеэтэй ижил түвшинд байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 53 бүртгэгдэж 24 хэргээр буюу 82.7 хувиар өссөн.

Нийт 29 хэргийг бүлгээр үйлдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 10 хэргээр буюу 52.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

172 гэмт хэрэгт 219 хүн холбогдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 81 хүнээр буюу 47 хувиар өссөн байна.

Захиргааны зөрчлийн талаар:

22998 зөрчилд 728.8 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 547 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийхээс 201 хүнээр буюу 58 хувиар өссөн байна. Зөрчлийн улмаас нийт 195 хүнийг баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулж, торгуулсан 187 иргэн байна



II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Аймгийн төсөв

Аймгийн төсвийн нийт орлого 43116.8 сая төгрөг, зарлага 40361.1 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 2755.7 сая төгрөгний эерэг гарлаа.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 3.6 хувь, урсгал орлого 4.6 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

Нийт орлогоос аймгийн төсвийн орлого 18.3 тэрбум төгрөг буюу 97.6 хувийн, сумдын төсвийн орлого 24.8 тэрбум төгрөг буюу 96.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Урсгал орлогын гүйцэтгэл 17.7 тэрбум төгрөг буюу 95.4 хувь байна.

Зураг II.1.1


Аймгийн төсвийн орлого, зарлага, сая.төг



Төсвийн нийт зарлага 40361.1 сая төгрөг буюу 84.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал 15895.6 сая төгрөг буюу 78.1 хувь, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зардал 24465.4 сая төгрөг буюу 89.2 хувь байна.

Зураг II.1.2

Аймгийн төсвийн өр, авлага, сүүлийн сараар



Нийт өр 144.7 сая, нийт авлага 13.9 сая төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал өр 201.0 сая төгрөгөөр буурч, авлага 11.1 сая төгрөгөөр өссөн байна. Өр өмнөх сараас 51.3 сая төгрөг, авлага 4.6 сая төгрөгөөр тус тус өсжээ. Нийт өрөөс цалин, НДШ-ийн өр 50.1 сая, тогтмол зардлын өр 35.8 сая, тээвэр шатахуун албан томилолтын өр 15.6 сая, эмийн өр 16.3 сая, бусад зардлын

өглөг 26.9 сая төгрөг байна. Хөтөлбөрөөр /салбараар/ авч үзвэл Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын байгууллагууд 46.1 сая, орон нутгийн байгууллага 54.4 сая, эрүүл мэндийн сайдын байгууллагууд 44.2 сая төгрөгийн өртэй байна.

II.2 Худалдан авах ажиллагаа

Орон нутгийн төсвөөс 38 төсөл арга хэмжээ буюу 1800.9 сая.төг, орон нутгийн хөгжлийн сангаас 8 төсөл арга хэмжээ буюу 2421.1 сая.төгрөг, авто замын сангаас 1 төсөл арга хэмжээ буюу 30.0 сая.төгрөг, байгаль хамгаалах сангаас 45 төсөл арга хэмжээ буюу 5431.2 сая.төг, улсын төсвийн хөрөнгө оруулалтын сангаас 9 төсөл арга хэмжээ буюу 7530.9 сая.төгрөг, нийт 101 төсөл арга хэмжээ буюу 17214.1 сая төгрөгийн төсөл арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж батлагдсанаас 13518.2 сая төгрөгийн төсөл арга хэмжээ гэрээ байгуулсан байна. Нийт 101 төсөл арга хэмжээнээс 34 арга хэмжээ 100% гүйцэтгэлтэй байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулвал орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 4.7 дахин, байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалт 3.2 дахин, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ 9 дахин өссөн бол авто замын сангийн хөрөнгө оруулалт 25 хувиар буурсан байна.




II.3 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеийнхээс 6.6 хувиар, оны эхнээс 4.5 хувиар, өмнөх сарынхаас 0.6 хувиар өссөн байна.

Зураг II.3.1

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2019 IX сар, (өмнөх сар =100%)



Хүснэгт II.3.1

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар,

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2019 IX 2018 IX	2019 IX 2018 XII	2019 IX 2019 VIII
Ерөнхий индекс	100.0	106.6	104.5	100.6
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	111.8	109.0	100.8
Согтууруулах ундаа, тамхи	3.2	101.6	102.0	99.9
Хувцас, бөс, бараа, гутал	16.1	103.0	101.2	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	107.0	103.9	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	106.0	105.2	104.9
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.6	102.1	101.0	99.0
Тээвэр	12.2	106.2	100.8	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	102.3	100.0	100.0
Амралт, чөлөөлт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	109.2	105.7	102.7
Боловсролын үйлчилгээ	4.7	111.6	111.6	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	122.3	119.6	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	102.5	104.2	101.5

II.4 Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар ноолуур 50.0 мян.төгрөг байна. Адууны шир 5.0 төгрөг, адууны дэл, адууны сүүл, үхрийн шир, хонины нэхий, ямааны арьс зах зээлд нийлүүлэлт байхгүй болсон байна.

II.5 Малын дундаж үнэ

Малын дундаж үнэ: тэмээ 970.0 мян.төг, адуу 570.0 мян.төг, үхэр 1170.0 мян.төг, хонь 165.0 мян.төг, ямаа 120.0 мян.төг болж буюу өмнөх оны мөн үетэй харьцуулвал адуу 9.6

хувиар буурсан бол тэмээ 7.7 хувиар, үхэр 45.7 хувиар, хонь 42.3 хувиар, ямаа 43.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.




II.6 Аж үйлдвэр

Аймгийн аж үйлдвэрийн газрууд 3969.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 5537.8 сая төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт нийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 2.1 хувиар, борлуулалт 9.1 хувиар тус тус буурсан байна. Аймгийн томоохон үйлдвэрлэлт хийгддэг гурилын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа эхлээгүй болно.

Зураг II.6.1

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт, борлуулалт /сая.төг/



II.7 Хөдөө аж ахуй

Мал төллөлт, төл бойжилт

Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1576.7 мянган хээлтэгч малын 1291.3 мянга буюу 81.9 хувь нь төллөсөн байна. Эм ямааны 81.6 хувь, эм хонины 84.3 хувь, ингэний 58.4 хувь, үнээний 71.1 хувь, гүүний 72.6 хувь төллөжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал мал төллөлт 13.6 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.


Гарсан төлийн 98.9 хувь буюу 1273.3 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулвал 1.7 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Зүй бусын хорогдол

Том малын зүй бусын хорогдол 20.5 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 83.9 мян.толгой мал буюу 81 хувиар буурсан байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 1.3 мянган толгой буюу 0.5 хувь, үхэр 1.4 мянган толгой буюу 0.5 хувь, хонь 11.1 мянган толгой буюу 0.6 хувь, ямаа 6.8 мянган толгой буюу 0.7 хувь нь оны эхний малаас тус тус хорогдоод байна. Нийт хорогдлын адуу 6.1 хувь, үхэр 6.9 хувь, ямаа 33.0 хувь, хонь 53.9 хувийг тус тус эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Баян-агт сум 41 хувийг, Сайхан сум 14.1 хувь, Хутаг-Өндөр сум 10.8 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна.

Зураг II.7.1

Зүй бусаар хорогдсон том малын эзлэх хувь



Зураг II.7.2

Зүй бусаар хорогдсон том мал, сумаар



II.8 Мал эмнэлгийн үйлчилгээ

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний вакциныг 936.6 мян.толгой малд хийхээр төлөвлөгдснөөс 610.3 мян.толгой малд вакцин хийж, 65.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний вакциныг 901.7 мян.толгой малд хийхээр төлөвлөгдсөнөөс 543.5 мян.толгой малд вакцин хийж, 60.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 2095.8 мян.толгой мал хамруулахаар төлөвлөгдснөөс 1523.3 мян.толгой малд тарилга, туулга хийж, 72.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мал амьтдын паразиттах өвчнөөр 208 голомтонд 18.0 мян.толгой мал өвчилж, 17.5 мян.толгой мал эдгэрч, 227 толгой мал үхсэн байна. Мониезиз, ширхтэх, ценуроз өвчин дийлэнх байна. Мал амьтдын халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 33 голомтонд гарч, 327 толгой мал өвчилж, 23 толгой мал эдгэрч, 302 толгой мал үхэж, 2 толгой малыг устгасан байна. Халдварт өвчний голомтын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулвал 56 хувиар, паразиттах өвчний голомт 65 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт II.8.1

Мал амьтны өвчин, хагас жилийн байдлаар

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	Паразит өвчин	Халдварт өвчин
Голомтын тоо	ш	208	33
Өвчилсөн	толгой	18007	327
Үхсэн	толгой	227	302
Эдгэрсэн	толгой	17574	23

Лабораторийн оношлогоо, шинжилгээнд 24.2 мян.толгой мал, тэжээвэр амьтан, 743.2 мян.кг мах, махан бүтээгдэхүүн, 37.6 мян.литр сүү, сүүн бүтээгдэхүүн, 3.83 мян.ширхэг арьс, шир, 0.081 мян.кг ноос ноолуур, 2.1 мян.кг дайвар, үзлэгт хамрагдаж, илэрсэн өвчин байхгүй, 100 хувь хэрэгцээнд тохирсон байна.

II.10 Газар тариалан

2019 онд аймгийн хэмжээнд нийт 49444.5 га талбайд тариалалт хийсэн байна. Үүнээс үр тариа 39853.5 га, төмс 373.1 га, хүнсний ногоо 132.4 га, техникийн ургамал 7586 га, тэжээлийн ургамал 1499.5 га талбайд тус тус тариалсан байна.

Хүснэгт II.10.1


Тариалсан талбай, га

Төрөл	2017-IX	2018-IX	2019-IX
Үр тариа	42992.7	42259.1	39853.5
Төмс	382.893	323.88	373.1
Хүнсний ногоо	146.11	149.583	132.4
Тэжээлийн ургамал	288	910.5	1499.5
Техникийн ургамал	4496	4641.2	7586

Тариалсан талбайг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт тариалсан талбай 2.4 хувиар буюу 1160.2 га-гаар өссөн байна. Үр тариа 5.7 хувиар, хүнсний ногоо 11.5 хувиар буурсан бол тэжээлийн ургамал 64.7 хувиар, техникийн ургамал 63.4 хувиар, төмс 15.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг II.10.1


Үр тариа, төмс, хүнсний ногооны тариалсан талбай, га





II.11 2019 оны 10 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээ

Бүс нутаг	I-р 10 хоног			II-р 10 хоног			III-р 10 хоног			
	Эхэн	Дунд	Эцэс	Эхэн	Дунд	Эцэс	Эхэн	Дунд	Эцэс	
Агаарын температурын сарын дундаж нь ихэнх нутгаар ОЖД-н орчим байх төлөлтэй										
Ихэнх нутгаар	Шөнө: +1.4 Өдөр: 12+17	Шөнө: -1.6 Өдөр: 9+14	Шөнө: -4.9 Өдөр: 2+7	Шөнө: -1.6 Өдөр: 9+14	Шөнө: -4.9 Өдөр: 2+7	Шөнө: -1.6 Өдөр: 9+14	Шөнө: -8.13 Өдөр: -2+3			
Хур тунадас: Энэ сард нийт нутгаар ОЖД-н орчим хур тунадас орох төлөлтэй										
Хур тунадас	Зарим газраар бага зэргийн хур тунадас нойтон цас	Хур тунадас оролгүй	Хур тунадас оролгүй	Зарим газраар бага зэргийн хур тунадас нойтон цас	Хур тунадас оролгүй	Ихэнх нутгаар хур тунадас нойтон цас	Хур тунадас оролгүй	Хур тунадас оролгүй	Зарим газраар цас	
Сэлж: Сэлж нэг ба хоёрдугаар арав хоногийн эхээр, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр зарим газраар 14-16м/с, нутгийн өмнөд хэсгээр түр зуур 16-18 м/с хүртэл ширүүн шороон болон цасан шуурга шурах төлөлтэй.										


-  - хур тунадасгүй
-  - хур тунадастай
-  - бороотой



дунджийн орчим ОЖДундаж нь 5.4мм-11мм

10 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв

Агаарын температур



дунджийн орчим ОЖДундаж нь -1.2°C -2.3°C


10 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв

Хур тунадас

Хүснэгт I.I.1 Хүн ам, өрх

Сум	Хүн ам				2018 2017	Эрэгтэй				2018 2017	Эмэгтэй				2018 2017
	2015	2016	2017	2018		2015	2016	2017	2018*		2015	2016	2017	2018	
Баян-Агт	3052	3119	3218	3251	101.0	1550	1583	1632	1645	100.8	1502	1536	1632	1604	100.9
Баяннуур	1868	1818	1861	1827	98.2	983	969	998	976	97.8	885	849	998	850	97.9
Бугат	2182	2241	2277	2198	96.5	1132	1187	1208	1157	95.8	1050	1054	1208	1041	95.8
Булган	12234	12512	12616	12582	99.7	6014	6104	6125	6150	100.4	6220	6408	6125	6422	100.6
Бүрэгхангай	2726	2832	2888	2872	99.4	1388	1459	1482	1469	99.1	1338	1373	1482	1399	99.4
Гурванбулаг	3133	3176	3219	3289	102.2	1617	1644	1660	1686	101.6	1516	1532	1660	1601	101.7
Дашинчилэн	2803	2941	3037	3008	99.0	1431	1492	1540	1523	98.9	1372	1449	1540	1482	99.1
Могод	2685	2701	2729	2711	99.3	1375	1383	1394	1392	99.9	1310	1318	1394	1318	99.9
Орхон	3482	3584	3595	3477	96.7	1865	1911	1913	1856	97.0	1617	1673	1913	1615	97.3
Рашаант	3141	3165	3215	3253	101.2	1583	1602	1618	1641	101.4	1558	1563	1618	1607	101.7
Сайхан	3575	3648	3662	3561	97.2	1816	1854	1871	1799	96.2	1759	1794	1871	1757	96.4
Сэлэнгэ	3207	3306	3332	3343	100.3	1666	1723	1733	1743	100.6	1541	1583	1733	1598	100.7
Тэшиг	3495	3504	3563	3560	99.9	1786	1782	1820	1809	99.4	1709	1722	1820	1751	99.4
Хангал	4548	4611	4705	4660	99.0	2282	2302	2343	2331	99.5	2266	2309	2343	2327	99.6
Хишиг-Өндөр	3154	3156	3158	3152	99.8	1592	1595	1592	1578	99.1	1562	1561	1592	1570	99.4
Хутаг-өндөр	4729	4835	4952	5050	102.0	2432	2487	2546	2573	101.1	2297	2348	2546	2467	101.5
Нийт хүн ам	60014	61149	62027	61794	99.6	30512	31077	31475	31328	99.5	29502	30072	31475	30409	99.7

Зураг I.I.1 Хүн амын нас хүйсийн суварга 2018 он



I.2 ХӨДӨЛМӨР

Хүснэгт I.2.1 Хөдөлмөр

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Үзүүлэлт	2018 I-IX		2019 I-IX		2019 I-IX % 2018 I-IX	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	1138	576	736	384	64.7	66.7
Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/	769	406	366	212	47.6	52.2
Ажилд зуучилсан иргэн /эдийн засгийн салбараар/	1102	437	654	317	59.3	72.5
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан, агнуур	246	81	129	53	52.4	65.4
Уул уурхай олборлолт	85	9	58	16	68.2	-
Боловсруулах үйлдвэр	91	37	20	11	22.0	29.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	19	0	3		15.8	-
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	14	13	11	9	78.6	69.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, холбоо мэдээлэл	8	1	1		12.5	0.0
Зочид буудал, байр, сууц болон нитийн хоолны үйлчилгээ	12	10	7	5	58.3	50.0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	27	18	30	12	111.1	66.7
Боловсрол	107	78	44	39	41.1	50.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	25	19	31	28	124.0	147.4
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа					-	-
Бусад	468	171	320	144	68.4	84.2
Бүртгэлтэй ажилгүй иргэн (насны бүлгээр)	769	406	366	212	47.6	52.2
15-24	120	61	71	39	59.2	63.9
25-34	273	151	140	83	51.3	55.0
35-44	204	114	90	55	44.1	48.2
45-54	144	70	52	31	36.1	44.3
55-59	19	6	10	2	52.6	33.3
60+	9	4	3	2	33.3	-
Бүртгэлтэй ажилгүй иргэн (боловсролын түвшнээр)	769	406	366	212	47.6	52.2
Магистр, доктор	1	1			0.0	0.0
Дипломын болон бакалаврын дээд	114	76	75	53	65.8	69.7
Тусгай мэргэжлийн дунд	28	17	9	3	32.1	17.6
Техникийн болон мэргэжлийн	38	19	18	8	47.4	42.1
Бүрэн дунд	480	249	217	120	45.2	48.2
Суурь	74	31	34	22	45.9	71.0
Бага	23	8	9	4	39.1	50.0
Боловсролгүй	11	5	4	2	36.4	40.0

I.3 НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хүснэгт I.3.2 Нийгмийн халамжийн зарлага, хамрагдсан хүн

Үзүүлэлт	Хүний тоо		Олгосон тэтгэвэр, тэтгэмж, мян. төг		2019 IX 2018 IX
	2018 IX	2019 IX	2018 IX	2019 IX	
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	10353	9656	3157553.7	3307496.7	104.7
Халамжийн тэтгэвэр	1167	1047	1342970.5	1482522.3	110.4
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	2869	2506	978721.1	1038356.3	106.1
Үүнээс:					
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн	1206	1081	156145.8	157149.9	100.6
Ахмад настныг асарч буй иргэний	1057	911	506972.8	555442.9	109.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг	381	335	197028.7	197590.7	100.3
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг	199	159	104779.4	115412.3	110.1
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөний	26	20	13794.4	12760.5	92.5
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт	6317	6103	835862.1	786618.1	94.1
Ахмад настуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж	1540	983	306362.0	287478.1	93.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	221	184	50550.4	62413.5	123.5
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	27		6100.0		0.0
Хүнс тэжээл хөтөлбөр	4,529	4936	462461.0	436726.5	94.4
Төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээ	0	0	10388.7	0	0.0

Хүснэгт I.3.3 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Үзүүлэлтүүд	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2019 I-IX 2018 I-IX
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	7582.2	8414.4	8831.9	7202	9177.4	127.4
Үүнээс:						
Тэтгэврийн даатгалын сан	4910.1	5225.5	5259.6	5996.8	7480.3	124.7
Тэтгэмжийн даатгалын сан	506.6	581	654	673.1	839.1	124.7
Эрүүл мэндийн даатгалын сан	1611.6	2064.3	2395.7			
ҮОМШӨ*-ний даатгалын сан	412.6	409.5	382.9	398.5	679.8	170.6
Ажилгүйдлийн даатгалын сан	141.3	134.1	139.7	133.6	178.2	133.4
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	23508.4	24058.4	25900.0	26846	30371.7	113.1
Үүнээс:						
Тэтгэврийн даатгалын сан	20840	20484.2	22072.0	25268.2	28627.8	113.3
Тэтгэмжийн даатгалын сан	805.1	830.5	874.7	941.0	1033.4	109.8

Эрүүл мэндийн даатгалын сан	1365.6	2154.7	2361.1			
ҮОМШӨ*-ний даатгалын сан	361.8	361.6	322.2	387.2	519.4	134.1
Ажилгүйдлийн даатгалын сан	135.9	227.4	270.0	249.6	191.1	76.6

Хүснэгт 1.3.4 Нийгмийн даатгалын сангийн зарлага, хүнээр

Үзүүлэлтүүд	Хүний тоо		Нийгмийн даатгалын сангийн зарлага сая.төг		2019 IX 2018 IX
	2018 IX	2019 IX	2018 IX	2019 IX	
Тэтгэврийн даатгалын сан	9132	9362	25268.2	28627.8	113.3
Тэтгэмжийн даатгалын сан	1556	1292	941.0	1033.4	109.8
ҮОМШӨ*-ний даатгалын сан	71	79	387.2	519.4	134.1
Ажилгүйдлийн даатгалын сан	126	131	249.6	191.1	76.6
Нийт дүн	10885	10864	26846	30371.7	113.1

I.4 ЭРҮҮЛ МЭНД

Хүснэгт 1.4.1 Аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн хүүхэд, нас баралт, төрлөөр, оноор

Үзүүлэлт	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2019/2018
Амаржсан эхийн тоо	607	602	616	570	92.5
Амьд төрсөн хүүхэд	670	609	623	581	93.3
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Амьгүй төрөлт	6	0	4	3	75.0
Гэрийн төрөлт	1	4	2	3	150.0
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	7	6	12	10	83.3
Перинаталь эндэгдэл	9	5	12	10	83.3
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	10.4	9.9	19.3	17.2	89.4

Хүснэгт 1.4.2 Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр, оноор

Үзүүлэлт	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2019/2018
Нийт гарсан халдварт өвчин	642	352	295	314	106.4
Гэдэсний халдварт өвчин	4	5	36	29	80.6
Амьсгалын замын халдварт өвчин	446	194	105	112	106.7
Байгалын голомтот халдварт өвчин	10	14	8	4	50.0
Бэлэгсийн замаар дамжих халдварт өвчин	156	118	127	139	109.4
Арьсны халдварт өвчин	26	21	19	31	163.2

I.5 ГЭМТ ХЭРЭГ

Хүснэгт I.5.1 Бүртгээгдсэн гэмт хэрэг, сумдаар

Сум	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	$\frac{2019 \text{ I-IX}}{2018 \text{ I-IX}} \%$
Булган	51	57	70	57	59	103.5
Баян-Агт	13	8	7	10	14	140.0
Баяннуур	8	5	8	6	9	150.0
Бугат	16	12	24	19	30	157.9
Бүрэгхангай	16	10	14	17	20	117.6
Гурванбулаг	10	7	9	8	18	225.0
Дашинчилэн	16	9	9	4	11	275.0
Могод	8	8	7	6	10	166.7
Орхон	31	21	36	15	64	426.7
Рашаант	6	5	12	12	16	133.3
Сайхан	7	11	12	11	14	127.3
Сэлэнгэ	11	4	18	9	21	233.3
Тэшиг	4	7	10	8	9	112.5
Хангал	4	4	19	9	9	100.0
Хишиг-Өндөр	12	7	13	7	28	400.0
Хутаг-Өндөр	7	18	15	24	31	129.2
Хялганат	10	1	8	4	4	100.0
Бүгд	230	194	291	226	367	162.4

Хүснэгт I.5.2 Хулгайн гэмт хэрэг, сумдаар

Сум	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX
Булган	12	19	30	23	19
Баян-Агт	3	2	3	7	12
Баяннуур	7	2	2	-	3
Бугат	5	6	8	2	8
Бүрэгхангай	8	4	2	6	10
Гурванбулаг	3	1	3	2	11
Дашинчилэн	11	4	2	2	6
Могод	1	5	2	3	5
Орхон	15	11	16	5	45
Рашаант	4	2	3	5	7
Сайхан	2	3	8	6	5
Сэлэнгэ	1	1	6	2	5
Тэшиг	1	1	1	2	1
Хангал	-	-	2	-	3
Хишиг-Өндөр	4	3	4	1	16
Хутаг-Өндөр	1	4	6	6	11
Хялганат	3	-	1	-	-
Бүгд	81	68	99	72	167

Хүснэгт 1.5.3 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Үзүүлэлт	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX
	сая.төгрөг				
Учирсан хохирол-Бүгд	623.8	543.2	1243.1	556.5	1215.5
Үүнээс:					
Нөхөн төлүүлсэн	267.8	386.6	307.2	191.9	453.3
Нөхөн төлүүлэлтийн хувь	49.3	31.1	55.2	34.5	37.3

Хүснэгт 1.5.4 Сумдын хэргийн илрүүлэлт

Сум	Бүртгэгдэх үедээ сэжигтэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг		Яллагдагчаар татаж ял сонгосон хэрэг		Хэргийн илрүүлэлтийн хувь	
	2018	2019	2018	2019	2018	2019
Булган	24	53	14	27	58.3	50.9
Баян-Агт	4	11	1	8	25.0	72.7
Баяннуур	2	7	1	4	50.0	57.1
Бугат	5	28	3	18	60.0	64.3
Бүрэгхангай	11	19	7	8	63.6	42.1
Гурванбулаг	5	15	2	10	40.0	66.7
Дашинчилэн	3	8	1	1	33.3	12.5
Могод	3	9	1	4	33.3	44.4
Орхон	9	59	5	27	55.6	45.8
Рашаант	6	10	1	3	16.7	30.0
Сайхан	7	10	1	3	14.3	30.0
Сэлэнгэ	4	18	1	10	25.0	55.6
Тэшиг	5	9	2	5	40.0	55.6
Хангал	3	7	1	3	33.3	42.9
Хишиг-Өндөр	2	24	1	14	50.0	58.3
Хутаг-Өндөр	7	27	3	9	42.9	33.3
Хялганат	1	1	1	1	100.0	100.0
Бүгд	101	315	46	155	45.5	49.2

II.2 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Хүснэгт II.2.1 Бараа, ажил үйлчилгээний худалдан авалт, сая.төгрөг

№	Үйлчилгээний нэр төрөл	2018		2019	
		Тоо, хэмжээ	Батлагдсан төсөвт өртөг	Тоо, хэмжээ	Батлагдсан төсөвт өртөг
1	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	8	811.3	38	1800.9
2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт	4	435.7	8	2,421.2
3	Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалт	14	2,044.2	45	5,431.2
4	Авто замын сангийн хөрөнгө оруулалт	4	250	1	30.0
5	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	1	774.5	9	7530.9
	Дүн	31	4315.7	101	17214.1

Хүснэгт II.2.2 Бараа, ажил үйлчилгээ, гүйцэтгэл, сая.төгрөг

№	Үйлчилгээний нэр төрөл	2019 I-IX		
		Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн	Гүйцэтгэл
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ				
1	Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газрын суудлын автомашиныг шинэчлэх	50.0		Гэрээ байгуулаагүй
2	Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын суудлын автомашиныг шинэчлэх	50.0	50.0	100%
3	Орхон сумын Засаг даргын тамгын газрын суудлын автомашиныг шинэчлэх	50.0	50.0	100%
4	Хангал сумын Засаг даргын тамгын газрын суудлын автомашиныг шинэчлэх	50.0		Гэрээ байгуулаагүй
5	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих, 75 хүүхэд /Сэлэнгэ сум/	835.4	792.6	40%
6	Эрүүл мэндийн төвийн барилгын засвар /Могод сум/	299.5	264.3	100%
7	Сургуулийн барилгын засвар /Баяннуур сум/	156.0	142.9	100%

8	Баян-Агт сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10.0	10.0	Гэрээ байгуулсан
9	Баяннуур сумын Засаг даргын тамгын газар, Соёлын төвийн компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10.0	10.0	Суманд эрх шилжүүлсэн
10	Бугат сумын Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	10.0	10.0	Гэрээ байгуулсан
